



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 319

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, 2020 оны 230 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хавсралтад заасан 215,000,000.00 (хоёр зуун арван таван сая) төгрөгийн балансын үнэ, 57,333,333.41 (тавин долоон сая гурван зуун гучин гурван мянга гурван зуун гучин гурван төгрөг дөчин нэгэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг “Засгийн газрын авто бааз” улсын төсөвт үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Хаянхярваа, “Засгийн газрын авто бааз” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Г.Чинзориг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашины улсын дугаарыг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хассан тодорхойлолт, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

*Д. Нарангэрэл*

Д.НАРАНГЭРЭЛ

13201286

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны 27 дугаар сарын 27 өдрийн  
318 дугаар тогтоолын хавсралт

"ЭРДЭНЭС МОНГОЛ" ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ  
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН

| д/д | Автомашинь марк, улсын дугаар, зориулалт, арлын дугаар         | Ашиглалтад орсон он | Балансын үнэ, (төгрөг)      | Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)                                                                       | Үлдэгдэл өртөг (төгрөг)                                                                                          | Шилжүүлэн авах хуулийн этгээд   |
|-----|----------------------------------------------------------------|---------------------|-----------------------------|------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------|
| 1   | Ниссан патрол Y-62, суудлын, 0884 УБМ, арал- JN1TANY62Z0100513 | 2018                | 215,000,000.00              | 57,333,333.41                                                                                        | 157,666,666.59                                                                                                   | "Засгийн газрын авто бааз" УТҮГ |
|     |                                                                |                     | 215,000,000.00              | 57,333,333.41                                                                                        | 157,666,666.59                                                                                                   |                                 |
|     | Нийт дүн                                                       |                     | (хоёр зуун арван таван сая) | (тавин долоон сая гурван зуун гучин гурван мянга гурван зуун гучин гурван төгрөг дөчин нэгэн мянган) | (нэг зуун тавин долоон сая зургаан зуун жаран зургаан мянга зургаан зуун жаран зургаан төгрөг тавин есөн мянган) |                                 |